

“ГРАНД СИСТЕМС” ХК

2025 оны 08 сарын 01

№ 25/08

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцааг эргүүлэн худалдан авч, халааслах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4, 49.2, 49.4, 49.5 дахь хэсэг, 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.7, Гранд Системс ХК-ийн Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.15, 4.16, дахь хэсгийг тус тус үндэслэн “Гранд Системс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Гранд Системс” ХК-ийн нийт гаргасан хувьцааны 5 (тав) хувиас хэтрэхгүй хэмжээний хувьцааг Тогтоолын Хавсралт №1-т заасан нөхцөлийн дагуу Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан эргүүлэн худалдан авч, халааслахаар шийдвэрлэсүгэй.
2. “Гранд Системс” ХК-ийн “Хувьцаа эргүүлэн худалдан авч, халааслах журам”-г Тогтоолын Хавсралт №2-р баталсугай.
3. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, Төлөөлөн удирдах зөвлөлийг холбогдох мэдээллээр хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал Д.Энхбилэгт даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



О.БОЛД



Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 25/08 тоот тогтоолын Хавсралт №1

№	ГРАНД СИСТЕМС ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВЧ, ХАЛААСЛАХ НӨХЦӨЛ	
1	Хувьцааг эргүүлэн худалдан авах үнийн дээд хязгаар (төгрөгөөр)	Монголын хөрөнгийн биржийн өмнөх өдрийн хаалтын ханшийн 15 (арван тав) хувь хүртэл
2	Эргүүлэн худалдаж авах нийт хувьцааны тоо	150,000 ширхэг хүртэлх
3	Багц арилжаагаар худалдан авах ханшийн дээд хязгаар	Нийлбэр дүнгээр 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий багц арилжааны буурах хэлбэлзэл өмнөх өдрийн хаалтын ханшийн 5 хувиас илүүгүй байх, өмнөх хэлбэлзэл нь өмнөх өдрийн хаалтын ханшийн 5 хувь хүртэл.
4	Хувьцааг эргүүлэн худалдаж авах захиалгын хугацаа	2025 оны 08 сарын 01-ний өдрөөс 2026 оны 08 сарын 01-ний өдрийг дуустал
5	Захиалга хүлээн авах	Харилцагч үнэт цаасны компаниуд
6	Төлбөр төлөх хугацаа	Энгийн арилжааны журмын дагуу арилжаа хийгдсэнээс хойш холбогдох дансанд ажлын 2 өдрийн дараа төлбөр хийгдэнэ.